

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ГРАНТ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг дэмжих зорилгоор грант олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Грант нь "Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх эсэг, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дүрмийн 2 дугаар заалтын 2.1.1-2.1.4-т заасны дагуу онолын суурь болон хавсарга судалгааны сэдэвт ажлыг санхүүжүүлэх хэлбэр байна.

Тайлбар: "Грант гэдэгт иргэн, хуулийн этгээд тодорхой судалгаа, шинжилгээний жил явуулахаар шинжлэх ухааны үйл ажиллагаанд оролцоход нь буцалтгүй, эргэн төлүүлэхгүйгээр олгож байгаа мөнгөн болон бусад хөрөнгө"-ийг ойлгоно.

1.3. Нийгмийн бодит хэрэгцээ болгох боломжтой онолын суурь болон практик судалгааны ажилд завсрын болон эцсийн үр дүнд зайлшгүй шаардлагатай нэмэлт судалгаа, ооцоо, үндэслэл, боловсруулалт хийлгэх зорилгоор иргэн хуулийн этгээдэд грантыг нэг жил үртэл хугацаатай олгоно.

Тайлбар: Хууль зүйн шинжлэх ухааны салбарт төрийн бодлого боловсруулахад шинжлэх ухааны үндэслэл болохуйц судалгааны үр дүн, олон нийтийн оюуны хэрэгцээг ангахуйц ном бүтээлийг бодит хэрэглээнд тооцно.

1.4. Грантаар санхүүжүүлэх ажлын хамтран гүйцэтгэгч нь магистрант болон оюутан байж болно.

1.5. Грантын зохих хувийг судалгааны ажилд зайлшгүй шаардлагатай ном, сэтгүүл, оног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон бусад материал худалдан авахад зарцуулж болох бөгөөд гадаад томилолтын болон суралцах зардалд зориулахыг хориглоно.

1.6. Грантын 40 хүртэлх хувийг гүйцэтгэгчийн цалинд зарцуулж болно.

Хоёр. Грантаар санхүүжүүлэх судалгааны үр дүнг сонгох, баталгаажуулах

2.1. Судалгааны ажлыг грантаар санхүүжүүлэх саналыг иргэн, хуулийн этгээд нээлттэй эгэх эрхтэй.

2.2. Энэхүү журмын 2.1-д заасан саналыг холбогдох бичиг баримтын хамт Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдмийн зөвлөл /цаашид "Эрдмийн зөвлөл" гэх/-д ирүүлнэ. Үүнд:

2.2.1. Судалгааны ажлын танилцуулга;

2.2.2. Судалгааны ажлыг гүйцэтгэснээр гарах үр дүн, практик ач холбогдлын паарх танилцуулга;

2.2.3. Грантаар хэрэгжүүлэх ажлын удирдамж, төлөвлөгөө, зардлын рийвчилсан тооцоо;

2.2.4. Грантын санхүүжилтээр зайлшгүй шаардлагатай ном, сэтгүүл, тоног хөөрөмж, багаж хэрэгсэл болон бусад материал худалдан авах бол тэдгээрийн талаарх лгэрэнгүй мэдээлэл;

2.2.5. Грантаар санхүүжүүлэх ажлыг гүйцэтгэх ажилтны ажил байдлын дорхойлолт, тухайн сэдэвтэй холбогдох бүтээлийн жагсаалт.

2.3. Грантыг олгохдоо Эрдмийн зөвлөлийн саналыг үндэслэн Захирал тушаал гаргана.

2.4. Грантаар санхүүжүүлэх ажлыг Хууль зүйн үндэсний хүрээлэн, гүйцэтгэх ажилтны оронд байгуулсан гэрээний дагуу хэрэгжүүлнэ.

2.5. Грантаар санхүүжүүлсэн ажлын үр дүнг Эрдмийн зөвлөл болон Захиралд ялагнана.

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ

16 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд санхүүжилт олгох
рам

16.1. Энэ хуулийн 14.1.1, 14.1.2-т заасан эх үүсвэрээс санхүүжүүлэх эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг Засгийн газраас баталсан журмын дагуу хянан магадлагаа өгж шалгаруулна.

16.2. Энэ хуулийн 16.1-д зааснаар шалгарсан эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг санхүүжүүлэхэд олгох хөрөнгийн хэмжээг Зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

16.3. Энэ хуулийн 16.1-д заасан ажлын захиалагч нь төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага байх бөгөөд тэдгээр нь Иргэний хуулийн 343-358 дугаар 11д заасны дагуу гүйцэтгэгчтэй төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээ байгуулна.

16.4. Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага үйл ажиллагааныхаа үндсэн төлөвлөлийн дагуу суурь, хавсарга судалгааг гүйцэтгэх бол тэдгээрт грант олгох, эсхүл уг байгууллагад санхүүжилт олгох замаар асуудлыг зохицуулж болно.

16.5. Энэ хуулийн 15.1.3-д заасны дагуу 14.1.3-14.1.5-д заасан эх үүсвэрээс гүйцэтгэх эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу санхүүжүүлнэ.

16.6. Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын барилга байгууламж, сорилт, туршилтын зориулалттай тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангахтай холбогдсон зардлыг улсын төсөвт тусгах, санхүүжүүлэх асуудлыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ДҮРЭМ

Хоёр. Хүрээлэнгийн үйл ажиллагааны зарчим, үндсэн чиг үүрэг

2.1. Хүрээлэн нь судалгаа, сургалт, сурталчилгаа, мэдээллийн байгууллагын үйлчилгээний үнэт зүйл, зарчмыг үйл ажиллагаандаа удиртгал болгож, дараах чиг үүргийг гэрэгжүүлнэ.

2.1.1. Хууль зүйн бодлогын судалгааг суурь, харьцуулсан бие даан хийхийн зэрэгцээ судлаар захиалан гүйцэтгүүлж болно.

2.1.2. Хуулийн төсөл боловсруулах ажилд бодлогын болон хавсарга судалгаагаар судлэхийн зэрэгцээ бусад мэдээллээр хангах чиг үүргийг гэрэгжүүлнэ. Хууль зүйн бодлогын судлаар хавсарга судалгааг төрийн байгууллагын захиалгаар хийж болно. Захиалсан байгууллага судалгааны ажлын зардлыг хариуцна.

2.1.3. Эрх зүйн харьцуулсан судалгаа хийх, үндэсний хууль тогтоомжийн төлөв судлал, хандлага гэрэгцээ, уялдаа, үр нөлөөг судалж санал, зөвлөмж, аргачлал товсруулна.

2.1.4. Төрийн захиргааны байгууллагуудад хуулийн гэрэгжилт, үр нөлөөг судлах судлаар арга зүйн туслалцаа үзүүлнэ. Энэ чиг үүргийг зөвлөмж, аргачлал боловсруулах, гэрөгөө өгөх, сургалт зохион байгуулах гэрэг арга хэлбэрээр гэрэгжүүлнэ. Холбогдох зардлыг тухайн байгууллага хариуцна.